3.Санхүүжилтийн гүйцэтгэл, ажлын чанарт хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ч.Жаргалсайхан), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (П.Баясан), Хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн орон нутгийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтын байдалд хяналт тавьж ажилллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг) -т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My Documents/ZAHNR-3A-4doc

021454

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 11 өдөр Дугаар А/447 Алтай хот

Есөнбулаг сумын II цэцэрлэгийн засварын ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "а" дахь заалт, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.4 дэх заалт, Засгийн газрын 2017 оны 69 дүгээр тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 1 дүгээр хавсралтын 1 дэх заалт, "Дүрэм шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолын 1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гамшгийн сангийн санхүүжилтээр Есөнбулаг сумын II цэцэрлэгийн засварын ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Д.Даваадорж	-Нийгмийн бодлого эрхэлсэн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	С.Цагаанбаатар	-Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн
Гишүүдэд:	Ц.Амарсанаа	-Онцгой байдлын газрын улсын байцаагч, ахмад
	Р.Пүрэвдорж	-Орон нутгийн өмчийн газрын өмч хариуцсан мэргэжилтэн
	Г.Бат-Эрдэнэ	-Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилгын хяналтын инженер
	Д.Ганчимэг	-Есөнбулаг сумын II цэцэрлэгийн эрхлэгч
	Р.Мөнхцэцэг	-"Хасагтын гоёл" ХХК-ийн инженер

2.Засвар шинэчлэлтийн ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, ажлын тоо хэмжээтэй нийцүүлэх, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч үр дүнг танилцуулахыг комисс (Д.Даваадорж)-т үүрэг болгосугай.

3.Орон нутгийн өмчид бий болсон хөрөнгийг хүлээж авсан акт, баримт бичгийг үндэслэн хөрөнгийн хөдлөлт өөрчлөлтийг хийж, хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Есөнбулаг сумын II цэцэрлэгийн эрхлэгч (Д.Ганчимэг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My Documents/ZAHNR-3A-4doc

021430

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 12 өдөр Дугаар А/1448 Алтай хот

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэн Сэрээнэгийн Билэгбаатарын орон сууцны зориулалтаар эзэмшиж байгаа 000025156 дугаартай эрхийн гэрчилгээ бүхий 2903 м2 газрын 300 м2 газрыг "Өргөө засал" ХХК-д эзэмших эрхийг шилжүүлж эзэмших газрын байршил, хэмжээг 1-3 дугаар хавсралтаар баталж эзэмшүүлсүгэй.

2.Хуулийн дагуу 000025156 дугаартай эрхийн гэрчилгээг хүчингүй болгож уг нэгж талбарыг эзэмшигч С.Билэгбаатар, "Өргөө засал" ХХК-д тус тус газар эзэмших гэрээ байгуулан гэрчилгээжүүлэхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Бямбадорж)-т даалгасугай.

3.Газар эзэмшигч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж буй байдалд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Б.Түмэнбаатар)-т даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны А/232 дугаар захирамжийнх 4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My Documents/ZAHNR-3A-4doc

021465

Аймгийн Засаг даргын 2019 оны
09 дугаар сарын 13-ны өдрийн А/148 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИГЧИЙН ЭЗЭМШИХ
ГАЗРЫН ЗОРИУЛАЛТ, БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ

Д/д	Эзэмшигчийн нэр	Зориулалт	Газрын хэмжээ /м2/	Хугацаа /жил/	Газрын байршил
1	С.Билэгбаатар	Орон сууц	2603	15	Жинст баг
2	"Өргөө засал" ХХК	Орон сууц	300	15	Жинст баг

__oOo__

Өргөө засал ХХК (3244911) - ИЙН
ЭЗЭМШИЖ БАЙГАА ГАЗРЫН БАЙРШЛЫН КАДАСТРЫН ЗУРАГ

Нэгж талбарын дугаар: 8208. . .

Хаяг: Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Жинст баг



Зургийн масштаб 1:1 000 (1 сантиметрт 10 метр багтана)

Аймгийн Засаг даргын
20 19 оны 09 дугаар сарын 12 -ны өдрийн
A/148 дугаар захирамжийн 2 -р хавсралт

Огноо: 2019-09-12

Хашааны координат:

Дугаар	X	Y	Урт	Цэгүүд
1	5138889.550	288557.918	18.54	1-2
2	5138907.403	288552.929	16.15	2-3
3	5138911.932	288568.429	18.71	3-4
4	5138893.914	288573.455	16.14	4-1

Талбайн хэмжээ: 300.0 квадрат метр

ИРГЭН Сэрээнэн ОВОГТОЙ Билэгбаатар (Д379110419) - ИЙН
ЭЗЭМШИЖ БАЙГАА ГАЗРЫН БАЙРШЛЫН КАДАСТРЫН ЗУРАГ

Аймгийн Засаг даргын
20 19 оны 09 дугаар сарын 12 -ны өдрийн
А/448 ... дугаар захирамжийн 3 -р хавсралт

Нэгж талбарын дугаар: 8208002104

Хаяг: Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Жинст баг



Зургийн масштаб 1:1 000 (1 сантиметрт 10 метр багтана)

Огноо: 2019-09-12

Хашааны координат:

Дугаар	X	Y	Урт	Цэгүүд
1	5138876.660	288534.157	22.18	1-2
2	5138897.956	288527.947	21.97	2-3
3	5138918.991	288521.598	10.36	3-4
4	5138916.003	288511.677	7.76	4-5
5	5138923.277	288508.977	4.77	5-6
6	5138921.836	288504.426	10.65	6-7
7	5138932.229	288502.116	34.43	7-8
8	5138941.959	288535.145	2.11	8-9
9	5138942.473	288537.193	24.39	9-10
10	5138948.424	288560.846	37.20	10-11
11	5138912.226	288569.419	17.20	11-12
12	5138907.400	288552.908	21.82	12-13
13	5138886.400	288558.838	26.53	13-1

Талбайн хэмжээ: 2555.0 квадрат метр

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 12 өдөр Дугаар А/449 Алтай хот

Тэмцээн уралдаан болон эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, 29.1.6-ын "г" дэх заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.6 дахь заалт, 3.1 дэх хэсэг, аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн 2019 оны 18 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дотрын тасгийн эрхлэгч, их эмч Д.Дорждагвын элэг шилжүүлэн суулгах эмчилгээний зардалд 1000000 төгрөг, Н.Хишигбаяр хүүгийн гадаад улсад эмчлүүлэх эмчилгээний зардалд 1000000 төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн "Бид оролцъё-Хамтдаа хөгжье" аймгийн зөвлөгөөн зохион байгуулахад 4000000 төгрөг, Олон Улсын хэмжээний мастер Э.Мөнхдөлийн Тайланд Улсын Баттая хотод зохион байгуулагдах тэмцээний зардалд 1000000 төгрөг, Ховд аймагт зохион байгуулагдах хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн "Тусгай олимпийн баруун бүсийн наадам"-д оролцох баг тамирчдын замын зардалд 500000 төгрөг, Э.Цогийн Үндэсний олон нийтийн телевизээс зохион байгуулж буй "Нинжа дайчид" тэмцээний зардалд 250000 төгрөг, Д.Бат-Эрдэнийн "Тариаланчид дуулж байна" улсын уралдааны зардалд 250000 төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2.Шаардагдах 8000000 (Найман сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ч.Жаргалсайхан)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Алтайбаатар)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My Documents/ZAHNR-3A-4doc

021/67

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 12 өдөр Дугаар А/450 Алтай хот

Тусгай зөвшөөрөл сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.5 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн "Журам батлах тухай" 2018 оны 45 дугаар тогтоолын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Согтууруулах ундааны худалдаа, үйлчилгээнд тавигдах шаардлагыг хангаж, спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахаар материалаа ирүүлсэн аж ахуйн нэгжийг нэгдүгээр хавсралтаар, тусгай зөвшөөрөл шинээр авахаар материалаа ирүүлсэн аж ахуйн нэгжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хууль тогтоомж, шаардлага, журмыг зөрчсөн тохиолдолд зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээ авч ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Б.Түмэнбаатар), Цагдаагийн газар (Д.Болдсайхан), холбогдох сумын Засаг даргад тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Баттайван)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My Documents/ZAHNR-3A-4doc

021471

Аймгийн Засаг даргын 20.19 оны
09 дугаар сарын 12-ны өдрийн А/140 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

СПИРТИЙН ӨНДӨР БОЛОН СУЛ АГУУЛАМЖТАЙ СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛИЙН ХУГАЦААГ СУНГАСАН АЖ АХУЙН НЭГЖҮҮД

№	Сумын харьяалал	Аж ахуйн нэгжийн нэр	Үйл ажиллагаа явуулах дэлгүүр, үйлчилгээний газрын нэр	Байрлал	Худалдаа, үйлчилгээний хэлбэр
1.	Есөнбулаг сум	"Цэлмэг мөрөн Алтай" ХХК	"Цэлмэг мөрөн Алтай" хүнсний дэлгүүр	Баянхайрхан баг	худалдах
2.	Дэлгэр сум	"Талын зээр" хоршоо	"Өнөр мөнх" хүнсний дэлгүүр	Гуулин тосгон	худалдах
3.	Цогт сум	"Өрнөх богд" ХХК	"Цогт овоо" хүнсний дэлгүүр	Сумын төв	худалдах
4.	Хөхморьт	"Цагаан зоос" ХХК	"Номин" хүнсний дэлгүүр	Сумын төв	худалдах

__oOo__

Аймгийн Засаг даргын 20.19 оны
09 дугаар сарын 12-ны өдрийн А/127 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

СПИРТИЙН ӨНДӨР БОЛОН СУЛ АГУУЛАМЖТАЙ СОГТУУРУУЛАХ УНДААГААР ҮЙЛЧЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖ

№	Сумын харьяалал	Аж ахуйн нэгжийн нэр	Үйл ажиллагаа явуулах дэлгүүр, үйлчилгээний газрын нэр	Байрлал	Худалдаа, үйлчилгээний хэлбэр
1.	Дэлгэр сум	"Бөх Мөнх" ХХК	"ТайГамна" караоке	Сумын төвд	үйлчлэх

__oOo__

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 13 өдөр Дугаар А/45-1 Алтай хот

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "а" дахь заалт, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 69 дүгээр тогтоолоор батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 1 дүгээр хавсралтын 1 дэх заалт, Засгийн газрын 2018 оны "Дүрэм шинэчлэн батлах тухай" 317 дугаар тогтоолын 1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдсэн ГААОНӨГ/201901022 дугаар гэрээт Төгрөг сумын 0.4 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын ажлыг хүлээн авч ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: Б.Бямбадорж -Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Нарийн бичгийн дарга:М.Мөнхцэцэг -Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын инженерийн байгууламж хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: М.Мандахжүү -Архивын тасгийн дарга
Д.Отгонжаргал-Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүчний хяналтын улсын байцаагч
Ц.Амарсанаа -Онцгой байдлын газрын гамшгаас хамгаалах улсын байцаагч, ахмад
Р.Пүрэвдорж -Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн
Б.Бээжин -"Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ийн үйлдвэрлэл эрхэлсэн дэд захирал бөгөөд ерөнхий инженер
Л.Алтангэрэл -Төгрөг сумын Засаг дарга
Н.Батбаяр -"Халиун-Азарга" ХХК-ийн захирал

2.Барилга байгууламжийг ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, ажлын тоо хэмжээтэй нийцүүлэх, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч үр дүнг танилцуулахыг комисс (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

3.Орон нутгийн өмчид бий болсон хөрөнгийг хүлээж авсан акт, баримт бичгийг үндэслэн тухайн байгууллагатай хамтран хөрөнгийн хөдлөлт өөрчлөлтийг хийж, хяналт тавьж ажиллахыг Төгрөг сумын Засаг дарга (Л.Алтангэрэл), Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг), цаашдын ашиглалт, арчилгаа хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг "Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК (А.Пүрэвсүрэн)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My Documents/ZAHNR-3A-4doc

021489

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 13 өдөр Дугаар А/452 Алтай хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх Алтай хотын нийтийн тээврийн үйлчилгээнд зориулан автобус худалдан авах ажлыг шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Есөнбулаг сумын 4 дүгээр сургуулийн захирал (Ч.Сэндэрмаа)-д олгосугай.

2.Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Есөнбулаг сумын 4 дүгээр сургуулийн захирал (Ч.Сэндэрмаа)-д үүрэг болгосугай.

3.Санхүүжилтийн гүйцэтгэл, ажлын чанарт хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ч.Жаргалсайхан), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (П.Баасан)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My Documents/ZAHNR-3A-4doc

021474

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 13 өдөр Дугаар А/1453 Алтай хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Үнэлгээний хорооны 2019 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 84 дүгээр зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжигдэх ГААОНӨГ/201907050 дугаартай Алтай хотын цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажлыг "О.Бат-Эрдэнэ ахлагчтай иргэдийн бүлэг"-тэй гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Бямбадорж)-т олгосугай.

2.Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

3.Санхүүжилтийн гүйцэтгэл, ажлын чанарт хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ч.Жаргалсайхан), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (П.Баасан), Хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн орон нутгийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтын байдалд хяналт тавьж ажилллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My Documents/ZAHNR-3A-4doc

021477

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 18 өдөр Дугаар А/454 Алтай хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Үнэлгээний хорооны 2019 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 84 дүгээр зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжигдэх ГААОНӨГ/201907049 дугаартай Нэгдсэн эмнэлгийн "Аз жаргалын цэцэрлэгт хүрээлэн"-д хийх тохижилтын ажлыг "Б.Батчимэг ахлагчтай иргэдийн бүлэг"-тэй гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Бямбадорж)-д олгосугай.

2.Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

3.Санхүүжилтийн гүйцэтгэл, ажлын чанарт хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ч.Жаргалсайхан), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (П.Баасан), Хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн орон нутгийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтын байдалд хяналт тавьж ажилллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My Documents/ZAHNR-3A-4doc

021480

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 13 өдөр Дугаар А/155 Алтай хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх Баянхайрхан багийн төвийн барилгын дээврийн засварын ажлыг шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Бямбадорж)-т олгосугай.

2.Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Есөнбулаг сумын Засаг дарга (Ш.Дагва)-д үүрэг болгосугай.

3.Санхүүжилтийн гүйцэтгэл, ажлын чанарт хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ч. Жаргалсайхан), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (П.Баасан), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Бямбадорж)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My Documents/ZAHNR-3A-4doc

021482

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 13 өдөр Дугаар А/458 Алтай хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Үнэлгээний хорооны 2019 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 83 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжигдэх ГААОНӨГ/201906004 дугаартай Засаг даргын Тамгын газрын засварын ажлыг "Аяга-Уул" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Засаг даргын Тамгын газар (Д.Баттайван)-т олгосугай.

2.Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (П.Баасан)-т үүрэг болгосугай.

3.Санхүүжилтийн гүйцэтгэл, ажлын чанарт хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ч.Жаргалсайхан), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (П.Баасан)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 16 өдөр Дугаар А/567 Алтай хот

Хамгаалалтын бүс тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 дахь заалт, Дэд бүтцийн хөгжлийн сайдын 2001 оны 55 дугаар тушаал, аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн 12 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Есөнбулаг сумын нутагт орших Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Говь-Алтай аймаг дахь нисэх буудлын аэродром орчмын аюулгүйн бүсийн эргэлтийн цэгийн солбицлыг нэгдүгээр хавсралтаар, хамгаалалтын бүсийн зураглалыг хоёрдугаар хавсралтаар тус тус тогтоосугай.

2.Аэродромын ойртолтын бүс буюу тусгай бүсээс цааш 12100 метр урттай зурвасын дагуу голчоос 2 тийш 500 метрийн өргөнтэй талбайд барилга байгууламж барих тохиолдолд Иргэний нисэхийн ерөнхий газар болон Нисэх буудалтай зөвшилцөх, газрын зөвшөөрөл олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Бямбадорж)-т зөвшөөрүүлсүэй.

3.Аэродромын үйл ажиллагаа эрхлэх дүрмийг мөрдөх, орчмын аюулгүйн бүсэд газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээг шинэчилж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Бямбадорж)-т даалгасугай.

4.Аэродромын орчмын аюулгүй бүсэд иргэн аж ахуйн нэгжийн явуулж буй үйл ажиллагаа нисэхийн аюулгүй байдалд нөлөөлж байгаа эсэхэд хяналт тавьж, тусгай бүсийн дэглэмтэй холбоотой мэдээллээр олон нийтийг хангаж ажиллахыг Есөнбулаг сумын Засаг дарга (Ш.Дагва), аймгийн Нисэх буудал (Д.Батбаяр)-д тус тус үүрэг болгосугай.

5.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (П.Баасан), Мэргэжлийн хяналтын газар (Б.Түмэнбаатар), аймгийн Нисэх буудал (Д.Батбаяр)-д тус тус үүрэг болгосугай.

6.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг Даргын 2018 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/23 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My Documents/ZAHNR-3A-4doc

021408

Аймгийн Засаг даргын 20[illegible]. оны
09 дугаар сарын ...-ны өдрийн [illegible] дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

АЭРОДРОМЫН АЮУЛГҮЙ БҮСИЙН СОЛБИЦОЛ

№	Өргөрөг	Уртраг
1.	46 21 21.030	96 17 11.525
2	46 22 45.707	96 08 56.547
3	46 23 48.589	96 09 18.923
4	46 22 23.888	96 17 34.051
5	46 22 37.076	96 25 50.055
6	46 15 28.417	96 24 20.355
7	46 22 31.297	96 00 40.651
8	46 22 40.224	96 02 08.638

__oOo__


7
8
3
4

Аймгийн Засаг даргын
2019 оны 09 дугаар сарын 16-ны өдрийн
А/457 дугаар захирамжийн 2-р хавсралт



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

20 19 оны 09 сарын 17 өдөр Дугаар А/458 Алтай хот

Үзэсгэлэн худалдаа зохион байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг, Сангийн сайдын 2018 оны 316 дугаар тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Жижиг дунд үйлдвэрийг дэмжих", "Үйлдвэржилт 21:100", "Эрүүл хүнс эрүүл монгол хүн", "Эрчимжсэн мал аж ахуй" үндэсний хөтөлбөрүүд, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд үйлдвэрлэл эрхлэгчдийн борлуулалтыг дэмжих, шинэ бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчилах, харилцан түншлэл тогтоох зорилгоор зохион байгуулагдаж байгаа "Алтай түншлэл-2019", "Үржлийн шилмэл мал-2019" баруун бүсийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулахад шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталсугай.

2.Дээрх арга хэмжээг зохион байгуулагдахад шаардагдах 14452000 (арван дөрвөн сая дөрвөн зуун тавин хоёр мянган) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ч.Жаргалсайхан)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ч.Жаргалсайхан), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (П.Баасан)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My Documents/ZAHNR-3A-4doc

021491

Аймгийн Засаг даргын 2019 оны
09 дугаар сарын 17-ны өдрийн А/458 дугаар
захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Зардлын нэрс	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Гран при дагалдах /мөнгөн шагнал/	ширхэг	1	200,000	200,000
2	Засаг даргын нэрэмжит шагналын мөнгөн шагнал	ширхэг	1	150,000	150,000
3	Бусад шагналыг дагалдах мөнгөн шагнал /тэргүүн/	ширхэг	15	120,000	1,800,000
4	Бусад шагналыг дагалдах мөнгөн шагнал /дэд/	ширхэг	15	100,000	1,500,000
5	Үржлийн шилмэл малын мөнгөн шагнал /тэргүүн/	ширхэг	20	150,000	3,000,000
6	Үржлийн шилмэл малын мөнгөн шагнал /дэд/	ширхэг	20	120,000	2,400,000
7	Үржлийн шилмэл малын мөнгөн шагнал /гутгаар/	ширхэг	20	100,000	2,000,000
8	Үржлийн шилмэл малын медаль	ширхэг	60	8,000	480,000
9	Үржлийн шилмэл малын гэрчилгээ	ширхэг	60	20,000	1,200,000
10	Шагналын цом /гранпри/	ширхэг	16	85,000	1,360,000
11	Өргөмжлөл	ширхэг	2	80,000	160,000
12	Өргөмжлөл /тэргүүн, дэд/	ширхэг	28	30,000	840,000
14	Аннос /гадна/	м2	30	10,000	300,000
15	Аннос	м2	24	8,000	192,000
16	Шилмэл малын аннос	м2	12	10,000	120,000
17	Бусад зардал /заалны чимэглэл, нээлтийн тууз, уяа, цэцэг, хайч, даавуу, урилга/	ширхэг			150,000
18	Заалны түрээс	өдөр	2	300,000	600,000
	Дүн				16,452,000
	Санхүүжүүлэх эх үүсвэр				
1	ОНХС-ийн хөрөнгө				14,452,000
2	Дэлхийн зөн Монгол Говь- Алтай орон нутгийн хөгжлийн хөтөлбөр				2,000,000
	Нийт санхүүжилтийн дүн				16,452,000

__oOo__

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 17 өдөр Дугаар А/459 Алтай хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гамшгийн сангийн хөрөнгөөр Малчдад захиалгын дагуу 160 тонн өвс нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Л.Батбаатар -Хүнс, хөдөө аж ахуйн газрын захиргаа удирдлын хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга: Н.Цэвэлмаа -Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Т.Болд -Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого өлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Б.Оюунчимэг-Төрийн бус байгууллагын төлөөлөл

Г.Энхбаяр -Есөнбулаг сумын иргэн

2.Тендерийн баримт бичгийг боловсруулж, батлуулан худалдан авах ажиллагааг хариуцлагатай, хууль журмын дагуу зохион байгуулж, дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо (Л.Батбаатар)-нд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My Documents/ZAHNR-3A-4doc

021503

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 17 өдөр Дугаар А/460 Алтай хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газрын тусламжийн хөрөнгөөр аймгийн Засаг даргын Тамгын газарт автомашин нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:	П.Баасан	-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлийн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Г.Алтангэрэл	-Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн
Гишүүд:	Н.Цэвэлмаа	-Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн
	Ц.Ачитмаа	-Төрийн бус байгууллагын төлөөлөл
	Б.Батбаатар	-Есөнбулаг сумын иргэн

2.Тендерийн баримт бичгийг боловсруулж, батлуулан худалдан авах ажиллагааг хариуцлагатай, хууль журмын дагуу зохион байгуулж, дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо (П.Баасан)-нд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My Documents/ZAHNR-3A-4doc

021501

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 17 өдөр Дугаар А/461 Алтай хот

Үзэсгэлэн худалдаа зохион байгуулахад
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, "Нэг сум- Нэг үйлдвэр" аймгийн дэд хөтөлбөрийн 4.3.5, "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зарцуулах журам"-ын 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Жижиг дунд үйлдпвэрийг дэмжих", "Үйлдвэржилт 21:100", "Эрүүл хүнс-Эрүүл монгол хүн", "Эрчимжсэн мал аж ахуй" үндэсний хөтөлбөрүүд, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд үйлдвэрлэл эрхлэгчдийн борлуулалтыг дэмжих, шинэ бараа бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчилах, харилцан түншлэл тогтоох зорилгоор зохион байгуулагдаж байгаа "Алтай түншлэл-2019", "Үржлийн шилмэл мал-2019" баруун бүсийн үзэсгэлэн худалдааг өргөтгөн зохион байгуулахад шаардлагатай худалдаа үйлчилгээний зориулалттай асар худалдан авах хөрөнгийг хавсралтаар баталсугай.

2.Дээрх арга хэмжээнд шаардагдах 9250000 (есөн сая хоёр зуун тавин мянган) төгрөгийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ч.Жаргалсайхан)-т зөвшөөрсүгэй.

3.Худалдаа үйлчилгээний зориулалттай асар авах ажлыг холбогдох хууль журмын хүрээнд гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Б.Баян-Эрдэнэ) -т олгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ч.Жаргалсайхан), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (П.Баасан), орон нутгийн өмчид бүртгэж авахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My Documents/ZAHNR-3A-4doc

021498

Аймгийн Засаг даргын 2019 оны
09 дугаар сарын 17-ны өдрийн А/461 дугаар
захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Цагаан асар /3*3 хэмжээтэй аймгийн сүлд бүхий логотой/	Ширхэг	10	925000	9250000
Нийт					9250000

__oOo__

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 17 өдөр Дугаар А/462. Алтай хот

"Үзэсгэлэн худалдаа зохион байгуулахад" дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, "Нэг сум- Нэг үйлдвэр" аймгийн дэд хөтөлбөрийн 4.3.5, "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зарцуулах журам"-ын 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Жижиг дунд үйлдпвэрийг дэмжих", "Үйлдвэржилт 21:100", "Эрүүл хүнс-Эрүүл монгол хүн", "Эрчимжсэн мал аж ахуй" үндэсний хөтөлбөрүүд, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд үйлдвэрлэл эрхлэгчдийн борлуулалтыг дэмжих, шинэ бараа бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчилах, харилцан түншлэл тогтоох зорилгоор зохион байгуулагдаж байгаа "Алтай түншлэл-2019", "Үржлийн шилмэл мал-2019" баруун бүсийн үзэсгэлэн худалдааг өргөтгөн зохион байгуулахад шаардлагатай худалдаа үйлчилгээний зориулалттай стенд худалдан авах хөрөнгийг хавсралтаар баталсугай.

2.Дээрх арга хэмжээнд шаардагдах 9920000 (есөн сая есөн зуун хорин мянган) төгрөгийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ч.Жаргалсайхан)-т зөвшөөрсүгэй.

3.Худалдаа үйлчилгээний зориулалттай стенд авах ажлыг холбогдох хууль журмын хүрээнд гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Б.Баян-Эрдэнэ) -т олгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ч.Жаргалсайхан), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (П.Баасан), орон нутгийн өмчид бүртгэж авахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

021495

Аймгийн Засаг даргын 2019 оны
09 дугаар сарын 17-ны өдрийн А/462 дугаар
захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Стенд /2*3 хэмжээтэй/	Ширхэг	62	160000	9920000
	Нийт				9920000

__oOo__

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 17 өдөр Дугаар А/468 Алтай хот

Соёлийн төвийн барилгын засварын
ажилд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Хилийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.1, 50.1.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.1 дэх хэсэг, Засаг даргын зөвлөлийн 2019 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 16 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Соёлийн өвийг хамгаалах үндэсний хөтөлбөрийн хүрээнд Алтай сум дахь хилийн цэргийн 0214-р ангийн соёлийн төвийн барилгын засварын ажилд дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах 10000000 (арван сая) төгрөгийг хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ч.Жаргалсайхан)-т зөвшөөрсүгэй.

3.Холбогдох хууль журмын дагуу худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллахыг Хилийн цэргийн 0214-р анги захирагч (дэд хурандаа Н.Батсайхан)-д тус тус даалгасугай.

4.Санхүүжилтийн гүйцэтгэл, ажлын чанарт хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ч.Жаргалсайхан), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (П.Баасан)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My Documents/ZAHNR-3A-4doc

021507

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 17 өдөр Дугаар А/464 Алтай хот

Монгол-Хятадын экспо арга хэмжээнд оролцох төлөөлөгчдийн замын зардалд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн 2019 оны 18 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Монгол-Хятадын экспо гурав дахь удаагийн арга хэмжээнд Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга П.Баасан, Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Б.Баян-Эрдэнэ, Ардын дуу бүжгийн "Алтай" чуулгын дарга Д.Отгонбаатар нарыг оролцуулсугай.

2.Замын зардалд шаардагдах 1000000 (Нэг сая) төгрөгийг Засаг даргын бэлтгэл хөрөнгөөс гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ч.Жаргалсайхан)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Э.Отгонбаяр)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 17 өдөр Дугаар А/465 Алтай хот

БНХАУ-ын Шинжан Уйгурын Өөртөө
Засах оронд ажиллах төлөөлөгчдөд
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалт, Аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн 19 дахь хурлын шийдвэрийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан БНХАУ-ын хил залгаа муж, хотуудтай хамтын ажиллагааны баримт бичиг байгуулж, харилцааг өргөжүүлэх зорилгоор Монгол Улсын Гадаад харилцааны яам, БНХАУ-ын ШУӨЗО-ны Ардын засгийн газар хоорондын 2019 оны 9 дүгээр сарын 18-20-ны өдрүүдэд болох Ажлын хэсгийн ээлжит хуралдаанд оролцох төлөөлөгчийн замын зардлыг хавсралтаар батлсугай.

2. Шаардагдах 2019340 (Хоёр сая арван есөн мянга гурван зуун дөчин) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ч.Жаргалсайхан)-т зөвшөөрсүгэй.

3. Илтгэх хуудсаа Засаг даргын зөвлөлд танилцуулахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Д.Отгонбаяр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

021508

Аймгийн Засаг даргын 2019 оны 09
дугаар сарын 18 өдрийн 1/165 дугаар
захирамжийн хавсралт

ДЮА0042

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын төрөл	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт
1.	ГАА-Булган- ГАА /890км*2=1780км/ 1 машин	1780	1920 /А92/	683520
2.	Такашкен-Үрүмч-Такашкен		337820	1035820
3.	Дурсгалын зүйл	3 ширхэг	100000	300000
	Нийт дүн			2019340

__o0o__

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 19 өдөр Дугаар А/466 Алтай хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Үнэлгээний хорооны 2019 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн 84 дүгээр зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх ГААОНӨГ/201907037 дугаартай Найрамдалын хорооны 1.3 км сайжруулсан зам барих ажлыг "Говь-Алтай АЗЗА" ХХК байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Бямбадорж)-д олгосугай.

2.Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

3.Санхүүжилтийн гүйцэтгэл, ажлын чанарт хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ч.Жаргалсайхан), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (П.Баасан), Хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн орон нутгийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтын байдалд хяналт тавьж ажилллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг) –т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

021519

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 19 өдөр Дугаар А/467 Алтай хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Үнэлгээний хорооны 2019 оны 9 дугаар сарын 4-ний өдрийн 84 дүгээр зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх БСШУСЯ/201902350 дугаартай Бигэр сумын Спорт заалны барилга барих ажлын шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Бямбадорж)-д олгосугай.

2. Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

3. Санхүүжилтийн гүйцэтгэл, ажлын чанарт хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ч.Жаргалсайхан), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (П.Баасан), Хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн орон нутгийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтын байдалд хяналт тавьж ажилллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)–т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

021516

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 23 өдөр Дугаар А/468 Алтай хот

"Гэгээн нуур-цэвэр ус" ОНӨААТҮГазрын
үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг
үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Ус" үндэсний хөтөлбөрийн 2.2.3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 84 дүгээр тогтоолоор батлагдсан "Хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усаар хангах хөтөлбөр"-ийн 3.2.4 дахь хэсэг, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зарцуулах журам"-ын 4.1 дэх заалт, Засаг даргын зөвлөлийн хурлын 2019 оны 9 сарын 16-ны өдрийн 19 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усаар хангах хөтөлбөр", "Ус" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд Алтай хотын иргэдийг эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усаар хангаж буй "Гэгээн нуур-цэвэр ус" ОНӨААТҮГазрын үйл ажиллагааг хэвийн тогтвортой явуулахад шаардагдах хөрөнгийн зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах 13.600.000 (арван гурван сая зургаан зуун мянган) төгрөгийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Санхүү төрийн сангийн хэлтэс (Ч.Жаргалсайхан)-т зөвшөөрсүгэй.

3.Шаардлагатай сэлбэг хэрэгсэлийг худалдан авч, техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг богино хугацаанд хийж, үйлдвэрийн хэвийн үйл ажиллагааг ханган үр дүнг тайлагнаж ажиллахыг "Гэгээн нуур-Цэвэр ус" ОНӨААТҮГазар (Ж.Гаваа)-т даалгасугай.

4.Санхүүжилтийн гүйцэтгэл, ажлын чанарт хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ч.Жаргалсайхан), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (П.Баасан), Хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтын байдалд хяналт тавьж ажилллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг) –т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

021534

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 23 өдөр Дугаар А/470. Алтай хот

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
дуудлага худалдаа зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоол, Барилга, хот, байгуулалтын сайдын 2018 оны 208 дугаар тушаал, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Алтай хотын инженерийн байгууламж бүхий бүсэд 3 нэгж талбарт газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдаа зарлан явуулах газрын хэмжээ, зориулалт, дуудлага худалдааны анхны үнийг 1 дүгээр хавсралтаар, байршлыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

2. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны шалгаруулалтыг 2019 оны 10 сарын 25-нд танхимаар зохион байгуулж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Бямбадорж)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

021523

Аймгийн Засаг даргын 20.19 оны
09 сарын 25-ны өдрийн А/170 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ДУУДЛАГА ХУДАЛДАА ЗАРЛАН ЯВУУЛАХ ГАЗРЫН БАЙРШИЛ, ЗОРИУЛАЛТ, ХЭМЖЭЭ, ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ АНХНЫ ҮНЭ

Д/д	Газрын байршил	Зориулалт	Газрын хэмжээ /м2/	Дуудлага худалдааны анхны үнэ/мянган төгрөг/
1	Баянхайрхан баг Солонго хороолол	Худалдаа, үйлчилгээ	678	6780.0
2	Баянхайрхан баг Солонго хороолол	Худалдаа, үйлчилгээ	678	6780.0
3	Баянхайрхан баг Солонго хороолол	Худалдаа, үйлчилгээ	678	6780.0

___o0o___

ГАЗАР ЭЗЭМШИХ ДУУДЛАГА ХУДАЛДААГААР
ЭЗЭМШИЖ БАЙГАА ГАЗРЫН БАЙРШЛЫН КАДАСТРЫН ЗУРАГ

Аймгийн Засаг даргын
20 19 оны 08 дугаар сарын 23 -ны өдрийн
А/170 дугаар захирамжийн 2 -р хавсралт

Нэгж талбарын дугаар: 8208...

Хаяг: Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Баянхайрхан баг, Солонго хороолол

Огноо: 2019-08-19



Зургийн масштаб 1:2 000 (1 сантиметрт 20 метр багтана)

Байршил 1: Талбайн хэмжээ: 678.0 квадрат метр

Дугаар	X	Y	Урт	Цэгүүд
1	5137926.580	287175.771	15.84	1-2
2	5137939.452	287166.543	42.84	2-3
3	5137964.412	287201.360	15.84	3-4
4	5137951.540	287210.588	42.84	4-1

Байршил 2: Талбайн хэмжээ: 678.0 квадрат метр

Дугаар	X	Y	Урт	Цэгүүд
1	5137961.538	287224.535	15.84	1-2
2	5137974.410	287215.307	42.84	2-3
3	5137999.370	287250.124	15.84	3-4
4	5137986.498	287259.352	42.84	4-1

Байршил 3: Талбайн хэмжээ: 678.0 квадрат метр

Дугаар	X	Y	Урт	Цэгүүд
1	5137996.496	287273.299	15.84	1-2
2	5138009.368	287264.071	42.84	2-3
3	5138034.328	287298.888	15.84	3-4
4	5138021.456	287308.116	42.84	4-1

Нийт талбайн хэмжээ: 2034.0 квадрат метр

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 25 өдөр Дугаар А/472 Алтай хот

Команд штабын сургалтад
хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны 147 дугаарр тогтоолоор баталсан "Мөнгө угаах болон терроризмийг санхүүжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр"-ийн 3.2.3, 5.1.1 дэх заалт, Засгийн газрын 2007 оны 175 дугаар тогтоолоор баталсан "Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөрийн 2.3.2, 2.3.3 дахь заалт, Терроризмтэй тэмцэх тухай хуулийн 5.1.4, 5.1.8 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн 19 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Агаарын хөлөг барьцаалагдсан үед орон нутгийн шуурхай штабыг зохион байгуулах нь" сэдэвт команд штабын сургалт, дадлага, эрсдэлийн үнэлгээний арга хэмжээний зардлыг хавсралтаар баталсугай.

2. Сургалтад шаардагдах 1044700 (Нэг сая дөчин дөрвөн мянга долоон зуун) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ч.Жаргалсайхан)-т зөвшөөрсүгэй.

3. Хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ч.Жаргалсайхан)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

021542

Аймгийн Засаг даргын 20..19 оны ..09..
дугаар сарын 25 өдрийн 144 дугаар
захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Хэрэглэх зүйлс	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Үнэ
1	Бичиг хэргийн зардал	2 ширхэг	11000	22000
2	Цайны завсарлага			131700
3	Өдрийн хоол	27	10000	270000
4	Оройн хоол	27	20000	540000
5	Гэрчилгээ	27	3000	81000
Нийт				1044700

__o0o__

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 25 өдөр Дугаар А/472 Алтай хот

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Алтай хотын инженерийн байгууламж бүхий газарт газар эзэмших хүсэлт гаргасан Аймгийн Засаг даргын Тамгын газрын эзэмших газрын зориулалт, хэмжээ, байршлыг 1-2 дугаар хавсралтаар баталж 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшсэн Аймгийн Засаг даргын Тамгын газарт газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулж, улсын бүртгэлд бүртгэхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Бямбадорж)-д зөвшөөрсүгэй.

3. Газар эзэмшигч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж буй байдалд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Б.Түмэнбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА В.РЭНЦЭНДОРЖ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

021525

Аймгийн Засаг даргын 2019оны
09. сарын 25-ны өдрийн А/472дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИГЧИЙН ЭЗЭМШИХ
ГАЗРЫН ЗОРИУЛАЛТ, БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ

Д/д	Эзэмшигчийн нэр	Зориулалт	Газрын хэмжээ /м2/	Хугацаа /жил/	Газрын байршил
1	Аймгийн Засаг даргын тамгын газар	Төрийн үйлчилгээ	63315.0	15	Баянхайрхан баг

___o0o___

Аймгийн Засаг даргын тамгын газар (9017585) - ИЙН ЭЗЭМШИХ ГАЗРЫН БАЙРШЛЫН КАДАСТРЫН ЗУРАГ

Аймгийн Засаг даргын
2019 оны 09 дугаар сарын 25-ны өдрийн
A/472 дугаар захирамжийн 2-р хавсралт

Нэгж талбарын дугаар: 8208 . . .

Хаяг: Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Баянхайрхан баг



